

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан .....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	15
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
Аудитын зөвлөмж .....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	19
4. Менежментийн захидал.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА  
Ц.НАЦАГДОЛГОР ТАНАА

2021.02.25 № 07/570  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Соёл урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Соёл урлагийн газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Байгууллага нь үндсэн чиг үүрэг, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтуудын хүрээнд үндсэн 6 хөтөлбөр, 30 арга хэмжээ зохион байгуулж, биелэлт 91.6 хувьтай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Аудитын гол асуудал

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг мөрдөөгүй, батлагдсан төсвийг эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр шилжүүлэн зарцуулсан, дуудлагын автомашиныг хувийн хэрэгцээнд

түрээсэлж ашигласан зэрэг зөрчлүүд нь Шилэн дансны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль эрх зүйн акттай нийцэхгүйгээс гадна үнэн зөв, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эвсэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эвсэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эвсэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эвсэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

			/Төгрөгөөр/
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>527,988.00</u></b>	<b><u>13,688,903.33</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	8,913,254.33
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	8,836,420.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	76,834.33
3351	Байгууллагаас авах авлага	-	76,834.33
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	527,988.00	4,775,649.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	527,988.00	4,775,649.00
35420	Аж ахуйн материал	472,989.00	2,720,949.00
35430	Сэлбэг хэрэгсэл	54,999.00	-
35470	Бусад хангамжийн материал	-	2,054,700.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>24,692,120.77</u></b>	<b><u>70,346,902.40</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	24,692,120.77	70,346,902.40
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	24,281,912.38	70,243,777.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,643,482.28	91,539,882.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,425,421.69)	(43,198,399.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,471,128.74	44,968,428.74
39208	Хуримтлагдсан элэгдэл	(21,407,276.95)	(23,066,133.74)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	410,208.39	103,124.90
39301	Программ хангамж	1,155,000.00	1,155,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(744,791.61)	(1,051,875.10)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>25,220,108.77</u></b>	<b><u>84,035,805.73</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>2,344,612.47</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	2,344,612.47
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	2,344,612.47
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	2,344,612.47
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,344,612.47
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>25,220,108.77</u></b>	<b><u>81,691,193.26</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	25,220,108.77	81,691,193.26
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	25,220,108.77	81,691,193.26
51210	Өмнөх үеийн үр дүн	25,220,108.77	25,220,108.77
51220	Тайлант үеийн үр дүн	-	56,471,084.49
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>25,220,108.77</u></b>	<b><u>84,035,805.73</u></b>



**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
			/Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,641,757,296.00</b>	<b>917,638,594.33</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,641,757,296.00</b>	<b>00.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>68,537,094.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	68,537,094.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		68,537,094.33
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	12,143,394.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	56,393,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,641,757,296.00</b>	<b>849,101,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,210,491,600.00	831,801,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,210,491,600.00	831,801,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	431,265,696.00	17,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,241,696.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	294,024,000.00	17,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000,000.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,641,869,868.43</b>	<b>861,167,509.84</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,641,869,868.43</b>	<b>861,167,509.84</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,565,042,528.73	708,137,475.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	242,017,016.00	239,881,472.22
210101	Үндсэн цалин	186,274,740.00	171,680,176.88
210102	Нэмэгдэл	55,742,276.00	68,201,295.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,527,043.00	28,633,604.00
210201	Тэтгэврийн даатгал	20,269,643.00	19,299,404.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,564,300.00	2,435,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,051,500.00	1,948,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	512,900.00	487,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,128,700.00	4,464,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,807,035.00	27,414,867.47
210401	Бичиг хэрэг	4,820,400.00	4,165,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,246,089.00	12,033,652.47
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,543,046.00	8,390,814.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,197,500.00	2,824,601.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	40,000.00	11,911,903.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,000.00	4,918,799.00
210604	Урсгал засвар	-	6,993,104.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	12,643,600.00	715,600.00
210702	Дотоод албан томилолт	12,643,600.00	715,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,112,972,235.30	325,972,980.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,105,972,235.30	318,972,980.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00

**Соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит**

<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	132,035,599.43	73,607,048.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,393,381.00	62,868,130.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,642,218.43	10,738,918.37
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	76,827,339.70	153,030,034.78
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	55,387,700.00	30,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	30,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,387,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	21,439,639.70	123,030,034.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,439,639.70	114,193,614.78
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт		8,836,420.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(112,572.43)</u></b>	<b><u>56,471,084.49</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(112,572.43)</u></b>	<b><u>56,471,084.49</u></b>



**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
			/төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,641,757,296.00</u></b>	<b><u>852,331,640.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.00	3,230,140.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	3,230,140.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	3,230,140.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,641,757,296.00</b>	<b>849,101,640.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,210,491,600.00	831,801,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,210,491,600.00	831,801,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	431,265,696.00	17,300,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	37,241,696.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	294,024,000.00	17,300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	100,000,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1,633,835,816.00</u></b>	<b><u>849,101,500.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,633,835,816.00</b>	<b>849,101,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,557,008,476.30</b>	<b>699,301,605.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	242,017,016.00	238,498,438.22
210101	Үндсэн цалин	186,274,740.00	170,297,142.88
210102	Нэмэгдэл	55,742,276.00	68,201,295.34
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,026,210.00	30,016,638.00
210201	Тэтгэврийн даатгал	19,768,810.00	20,276,638.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,564,300.00	2,435,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,051,500.00	1,948,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	512,900.00	487,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,128,700.00	4,870,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,861,035.00	25,387,955.00
210401	Бичиг хэрэг	4,309,400.00	4,165,800.00
210402	Тээвэр, шатахуун	19,246,089.00	10,099,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,543,046.00	8,297,754.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,762,500.00	2,824,601.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	94,999.00	12,952,604.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	94,999.00	5,959,500.00
210604	Урсгал засвар	-	6,993,104.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	12,643,600.00	715,600.00
210702	Дотоод албан томилолт	12,643,600.00	715,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,112,972,235.30	327,738,260.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,105,972,235.30	320,738,260.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	125,393,381.00	63,992,110.00

Соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	125,393,381.00	63,992,110.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>76,827,339.70</b>	<b>149,799,894.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	55,387,700.00	30,000,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	30,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	24,387,700.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	21,439,639.70	123,030,034.78
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,439,639.70	110,963,474.78
213305	Төвлөрүүлэх шилжүүлэг-Нэмэлт санхүүжилт		8,836,420.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>7,921,480.00</u></b>	<b>≡</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,921,480.00</b>	<b>-</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,921,480.00</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	7,921,480.00	-
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	7,921,480.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(7,921,480.00)</u></b>	<b>≡</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	00.00	00.00	25,332,681.20	25,332,681.20
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>25,332,681.20</b>	<b>25,332,681.20</b>
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-112,572.43	284,092,943.79
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>25,220,108.77</b>	<b>25,220,108.77</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>25,220,108.77</b>	<b>25,220,108.77</b>
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	56,471,084.49	56,471,084.49
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>81,691,193.26</b>	<b>81,691,193.26</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	834,801,500.00	831,801,500.00	3,000,000.00	99.6
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	834,801,500.00	831,801,500.00	3,000,000.00	99.6
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	803,121,500.00	690,838,025.22	112,283,474.78	86.0
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	243,500,000.00	238,498,438.22	5,001,561.78	97.9
Үндсэн цалин	173,177,100.00	170,297,142.88	2,879,957.12	98.3
Нэмэгдэл	70,322,900.00	68,201,295.34	2,121,604.66	97.0
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	32,872,600.00	30,016,638.00	2,855,962.00	91.3
Тэтгэврийн даатгал	23,132,600.00	20,276,638.00	2,855,962.00	87.7
Тэтгэмжийн даатгал	2,435,000.00	2,435,000.00	0.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	1,948,000.00	1,948,000.00	0.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	487,000.00	487,000.00	0.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	4,870,000.00	4,870,000.00	0.00	100.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	26,816,600.00	25,387,955.00	1,428,645.00	94.7
Бичиг хэрэг	4,269,600.00	4,165,800.00	103,800.00	97.6
Тээвэр, шатахуун	10,653,400.00	10,099,800.00	553,600.00	94.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,730,500.00	8,297,754.00	432,746.00	95.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,163,100.00	2,824,601.00	338,499.00	89.3
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	12,979,200.00	12,952,604.00	26,596.00	99.8
Багаж, техник, хэрэгсэл	5,959,500.00	5,959,500.00	0.00	100.0
Урсгал засвар	7,019,700.00	6,993,104.00	26,596.00	99.6
<b>Томилолт, зочны зардал</b>	715,600.00	715,600.00	0.00	100.0
Дотоод албан томилолт	715,600.00	715,600.00	0.00	100.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	412,102,200.00	319,274,680.00	92,827,520.00	77.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	405,102,200.00	312,274,680.00	92,827,520.00	77.1
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.0
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	74,135,300.00	63,992,110.00	10,143,190.00	86.3
Бараа үйлчилгээний бусад зардал	74,135,300.00	63,992,110.00	10,143,190.00	86.3
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,680,000.00</b>	<b>140,963,474.78</b>	-109,283,474.78	445.0
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	31,680,000.00	30,000,000.00	1,680,000.00	94.7

Соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,000,000.00	30,000,000.00	0.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,680,000.00	-		
<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>110,963,474.78</b>		
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	110,963,474.78		
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	834,801,500.00	831,801,500.00	-	100
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	834,801,500.00	831,801,500.00	-	100
Улсын төсвөөс санхүүжих	834,801,500.00	831,801,500.00	-	100
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	17	17	-	100
Удирдах ажилтан	1	1	-	100
Гүйцэтгэх ажилтан	14	14	-	100
Үйлчлэх ажилтан	2	2	-	100

**2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>17,300,000.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>17,300,000.00</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>8,463,580.00</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>8,463,580.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		8,463,580.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>8,836,420.00</b>
Төвлөрүүлэх шилжүүлэг (нэмэлт санхүүжилт)		8,836,420.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>17,300,000.00</b>
<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>17,300,000.00</b>
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		0.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,300,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		0.00
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		



### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, худалдан авалтыг хуулийн дагуу мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Шинэ их тэрбум аудит” ХХК-ийн ахлах аудитор Ц.Мишигдорж, аудитор О.Мөнх-Эрдэнэ нар хариуцаж хэрэгжүүлэв.

Соёл урлагийн газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоот албан бичгээр хүргүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Соёл урлагийн газрын эрхэм зорилго нь төрөөс соёл урлагийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар соёл урлагийн салбарын нийгэм эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд оршино.

Соёл урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хувь хүний хөгжил, нийтийн соёлыг дэмжсэн, өрсөлдөөнд суурилсан соёл, урлагийн хүртээмжтэй, олон талт үйлчилгээг нийгэмд хүргэж чадахуйц өрсөлдөх чадвар бүхий тогтвортой, хариуцлагатай, үр ашигтай үндэсний үйлчилгээний тогтолцоо, соёлын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бэхжүүлэх
- Соёлын өвийн бүртгэл, хяналт, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлах, баяжуулах, өвлүүлэх найдвартай тогтолцоог бэхжүүлэх;
- Соёл урлагийн салбарын тоо, бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, нэгдсэн системд оруулж үйл ажиллагааг тогтворжуулах
- Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах
- Нээлттэй, ил тод, шуурхай, чанартай, хүртээмжтэй ажил, үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Коронавируст халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 168 дугаар тогтоол

- Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 171 дүгээр тогтоол

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Соёл урлагийн газар санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцээгүй байна.

Соёлын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 оны шилэн дансны мэдээлэлд хийсэн дотоод аудитаар Соёл урлагийн газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 76.5 хувьтай буюу “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэн цаашид анхаарах алдаа, зөрчилтэй асуудлыг тодорхойлж танилцуулсан байв.

Соёл урлагийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтын нэгж байхгүй тул дотоод хяналт үр нөлөөгүй гэж дүгнэхэд хүрсэн.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,641,869.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 16,418.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 861,167.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,611.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тус тус тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58,815.7 мянган төгрөгөөр буюу 233 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		8,913.3	8,913.3
Бараа материал	528.0	4,775.6	4,247.6
Үндсэн хөрөнгө	24,692.1	70,346.9	45,654.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>25,220.1</b>	<b>84,035.8</b>	<b>58,815.7</b>
Өр төлбөр		2,344.6	2,344.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	25,220.1	81,691.2	56,471.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>25,220.1</b>	<b>84,035.8</b>	<b>58,815.7</b>

Авлага дансны үлдэгдэл 8,913.3 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилттэй холбоотой үүссэн 8,836.5 мянган төгрөгийг Соёлын яамнаас, 76.8 мянган төгрөгийг Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс авах авлага юм.

Бараа материалын дансны үлдэгдэл 4,775.6 мянган төгрөг болж 4,247.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материал шинээр худалдаж авснаас шалтгаалжээ. Тайлант онд 13,770.1 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авч, 9,522.4 мянган төгрөгийн материал зарцуулж, 4,775.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 70,346.9 мянган төгрөг болж 45,654.8 мянган төгрөгөөр өссөн нь Соёлын яамнаас 23 нэр төрлийн компьютер техник хэрэгсэл, тавилга эд хогшлыг үнэ төлбөргүйгээр шилжүүлж авснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь 50,849.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 5,544.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр худалдан авч, нийт 56,393.7 мянган төгрөгөөр өссөн, 10,738.9 мянган төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Биет бус хөрөнгө нь тайлант онд 307.1 мянган төгрөгөөр хорогдлын зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,344.6 мянган төгрөгөөр өссөн нь шуудан, тээвэр, үйлчилгээний төлбөрийг хугацаанд нь төлөөгүйгээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 81,691.2 мянган төгрөг болж 56,471.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 56,471.1 мянган төгрөгийн үр дүнтэй ажилласнаас шалтгаалжээ.

Соёл урлагийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 724,118.7 мянган төгрөгөөр буюу 44 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 378,690.1 буурсан, нэмэлт санхүүжилтийн орлого 413,965.7 буурснаас шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 780,702.4 мянган төгрөгөөр буюу 48 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь санхүүжилт буурснаас төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт буурснаас шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,211,404.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,211,404.5 мянган төгрөгөөр тоцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны байгууллага төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 376,603.0 мянган төгрөгөөр бууруулж 834,801.5 мянган төгрөгөөр баталсан байна. Өмнөх оны баталсан төсвөөс 375,569.1 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь Монгол улсын Засгийн газрын баталсан “Коронавируст халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 2020 оны 168 дугаар тогтоолд заасны дагуу зохицуулалт хийгдсэнээс шалтгаалжээ.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 6 хөтөлбөрийн 30 арга хэмжээг санхүүжүүлэхээр 831,801.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 831,801.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр улсын төсвөөс 831,801.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 831,801.5 мянган төгрөгийг зарцуулж 110,963.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 831,801.5 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 92,827.5 мянган төгрөгөөр дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь соёлын өв хамгаалах, музейн үзвэр авах зэрэг үндэсний хөтөлбөрийн зарим зардлыг дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 17,300.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс “Бүх нийтийн хөгжмийн баяр-2020” нэгдсэн арга хэмжээнд 8,463.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 8,836.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны мэдээллийг бүртгэл тайлантай тулган шалгахад 1,368,684.4 мянган төгрөгийн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш дүнтэй орлого, зарлагын мэдээллээс шилэн дансанд 1,735,704.9 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлж, 367,020.6 мянган төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн байна.

Мөн зарлагын эрсдэлтэй гэж үзсэн 226,532.9 мянган төгрөгийн гүйлгээг түүвэрлэн шалгахад зарим гэрээт ажлын хувьд гэрээ дүгнэсэн актгүй шууд мөнгийг шилжүүлсэн, шилэн дансны мэдээлэлд дутуу, зөрүүтэй мэдээлсэн ба шилэн дансны орлого, зарлагын нийт 30 гүйлгээний хувьд 29 гүйлгээ нь дэмжих баримтууд болох тушаалыг хавсаргаагүй, тушаалын нэрийг бичсэн байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 65 хувьтай байна гэж дүгнэв.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	1	-	1	-	65%
Нийт дүн	2	-	1	-	1	-	65%

Өмнөх аудитаар 2 зөвлөмж өгснөөс тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч баталж мөрдсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, шилэн дансны зарим мэдээллийг хугацаа хоцроосон, нэг мэдээллийг бүрэн оруулаагүй 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30,670.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,913.9 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, өмнөх зөвлөмжийн шилэн дансны хэрэгжилт болон төсвийг зориулалт бусаар шилжүүлэн зарцуулалтын 25,036.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэх, 3,720.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгөх.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1,913.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, өмнөх зөвлөмжийн дутуу хэрэгжилт болон төсвийг зориулалт бусаар шилжүүлэн зарцуулалтын 25,036.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлэх. Үүнд:

1. Соёл, урлагийн газрын ахлах нягтлан бодогч нь тайлант онд Засгийн газрын автобаазын автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглаж, 1,913.9 мянган төгрөгийг түрээсийн төлбөрт төлж үргүй зардал гаргасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”* 16 дугаар зүйлийн 16.5.5. *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”* заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан тул төлбөрийн акт тогтоох;

2. Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны мэдээлэл санхүүгийн мэдээллээс зөрүүтэй илэрхийлэгдэж өмнөх зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2. *“Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана.”* заалт, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1. *“Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, 4.1.3. тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;”* заалттай нийцэхгүй үнэн зөв байдал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

3. Батлагдсан төсвөөс 25,036.0 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүй шилжүүлэн зарцуулсан. Гэрээт ажлыг гүйцэтгэгч байгууллагаас ажлын баримт, ажлын тайлан хүлээж аваагүй байна. Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5. *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”*; Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын

3.1.5-д “Тухайн төсвийн захирагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдсан байх” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх;

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 3,720.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор 2021 оны хаврын чуулганаар хуулийн төслийг хэлэлцэхээр төлөвлөсөн тул шинэчилсэн хуультай холбоотойгоор соёлын газрын чиг үүрэг, дотоод зохион байгуулалтын бүтэц өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.



#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### *1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал*

###### 1.1. Илрүүлэлт:

Түүхийн дурсгалт үзвэр, соёл, урлагийн бүтээлүүдийг худалдаж авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 34.1.1 "оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээг зөвхөн нэг этгээдтэй байгуулах боломжтой бөгөөд түүнийг орлох этгээд байхгүй бол" гэсэн заалтын дагуу холбогдох худалдан авалтад шууд гэрээ байгуулах арга хэрэглэж ирсэн. Худалдан авалтын үйл ажиллагаанд хуулийн доорхи заалт зөрчигдсөн байна. Үүнд: 34.2. "Энэ хуулийн 34.1-д заасан нөхцөлийн дагуу шууд гэрээ байгуулахад захиалагч энэ хуулийн 14-16 дугаар зүйлийн шаардлагыг хангасан, тухайн бараа, ажил, үйлчилгээг гүйцэтгэх чадавхтай нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдтэй хэлэлцээ хийж, техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл, шаардлагыг хамгийн сайн хангасан этгээдтэй энэ хуульд заасны дагуу гэрээ байгуулах бөгөөд хэлэлцээний үед хүрсэн аливаа тохиролцоог гэрээнд тусгана." 34.3. "Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ." заалтуудыг мөрддөггүй. Энэ нь үнэн зөв байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн.

###### 1.2. Эрсдэл:

Хуулийн заалтыг мөрдөөгүйгээс төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах.

###### 1.3. Өгсөн зөвлөмж

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу гэрээ шууд байгуулахаар бол гүйцэтгэгч талын санхүүгийн чадавхи, хараат бус байдал, сүүлийн 3 жил гэрээний үүргээ биелүүлсэн зэрэг санхүүгийн болон техникийн чадваруудыг үнэлж баримтжуулан, хамгийн сайн үнэлэгдсэн этгээдтэй гэрээ байгуулж, гэрээний хувь болон тайлбар үндэслэлийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж байх ;

###### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид өгөгдсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

##### *2. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал*

###### 2.1. Илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн зарлагын зарим баримтууд нь төлбөрийн и-баримтуудаар баталгаажуулж, 3,720.6 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт бүрдэлгүй. Бараа материалын тайланг хүчин төгөлдөр болгож бүрдүүлээгүй. Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." 13.5. "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын

үсгээр баталгаажсан байна;" 13.7."Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." заалтуудыг тус тус зөрчсөн.

2.2. Эрсдэл:

Анхан шатны баримтыг хуулийн дагуу хүчин төгөлдөр бүрдүүлээгүйгээс орлого, зардлыг хүлээн зөвшөөрөхгүйд хүрэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Мөнгөн хөрөнгийн зарлагын баримт болон бараа материалын худалдан авалтын баримтуудыг иж бүрэн бүрдүүлж, төлбөрийн и-баримтыг хавсаргаж байх;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид өгөгдсөн зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Соёл урлагийн газрын ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			САГ-2021/104/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Соёл урлагийн газар</b>		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	1,913.9 мянган төгрөгийн дуудлагын автомашиныг хувийн хэрэгцээнд ашигласан.	1,913.9	Акт	Дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор А.Түвшин
2	Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй, шилэн дансны мэдээлэл санхүүгийн мэдээллээс зөрүүтэй илэрхийлэгдэж өмнөх зөвлөмжийг дутуу хэрэгжүүлсэн	-	Албан шаардлага	Дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор Б.Ууганцэцэг
3	Батлагдсан төсвөөс 25,036.0 мянган төгрөгийг дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүй шууд худалдан авалтаар зарцуулсан.	25,036.0	Албан шаардлага	Дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор Б.Ууганцэцэг
4	Түүхийн дурсгалт үзвэр, соёл, урлагийн бүтээлүүдийг худалдаж авахдаа "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн заалтуудыг мөрддөггүй.	-	Зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор Б.Ууганцэцэг
5	Мөнгөн хөрөнгийн зарлагын зарим баримтууд нь төлбөрийн и-баримтуудаар баталгаажуулаагүй. 3,720.6 мянган төгрөгийн үнэ бүхий бараа материалын худалдан авалтын анхан шатны баримт бүрдэлгүй. Бараа материалын тайланг хүчин төгөлдөр болгож бүрдүүлээгүй.	3,720.6	Зөвлөмж	Дарга, Ахлах нягтлан бодогч	Ц.Нацагдолгор Б.Ууганцэцэг
<b>ДҮН</b>		<b>30,670.5</b>			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2021 оны 02 дугаар сарын 25

№ 52/АД160058

Улаанбаатар хот

СМГ-0021/104/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл, урлагийн газрын ахлах нягтлан бодогч нь тайлант онд Засгийн газрын автобаазын автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглаж, 1,913,900 (нэг сая есөн зуун арван гурван мянга есөн зуун) төгрөгийн түрээсийн төлбөрт төлж, үргүй зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5. "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Соёл урлагийн газрын дуудлагын автомашины ашиглалтын зардал 1,913,900 (нэг сая есөн зуун арван гурван мянга есөн зуун) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, ахлах нягтлан бодогч А.Түвшин нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АХЛАХ АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.МИШИГДОРЖ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 138/А0160058

Улаанбаатар хот

САГ-2021/04/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаанд нь оруулсан 119 мэдээлэл, хугацаа хоцроосон 28 мэдээлэл, мөн 2 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн “4.1.1-д мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, “4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх,” 6 дугаар зүйлийн 6.4. “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” 6.4.5.”цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, ахлах нягтлан бодогч Б.Ууганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:

Б.СЭРЖМЯДАГ

ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.МИШИГДОРЖ







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 193/АО 160058

Улаанбаатар хот

С.АТ-2021/104/СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дээд шатны төсөв захирагчийн зөвшөөрөлгүйгээр 25,036.0 мянган төгрөгийг батлагдсан хөтөлбөр, арга хэмжээний төсөв хооронд гүйлгэн зарцуулсан байна. Үүнд:

- Музейн үзмэр худалдан авах арга хэмжээний 116,967.3 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс 5,000.0 мянган төгрөгийг Соёлын яамны 100 жилийн ойн дурсгалын медалийн эскиз гаргах зардалд,
- Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах арга хэмжээний 164,584.4 мянган төгрөгийн батлагдсан төсвөөс судалгааны ажил, кино контент бүтээх, дүрслэх урлагийн шилдэг бүтээл хэвлэхэд нийт 20,036.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, гүйцэтгэгч байгууллагаас ажлын тайланг хүлээж аваагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.5-т "Тухайн төсвийн захирагчийн үйл ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөтэй нягт уялдсан байх" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."; Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Үйл ажиллагааны зардлыг төсвийн дээд шатны захирагчийн зөвшөөрлөөр захиран зарцуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын дарга Ц.Нацагдолгор, ахлах нягтлан бодогч Б.Ууганцэцэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ

Ц.МИШИГДОРЖ



## ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing, consisting of 30 lines spaced evenly down the page.

